



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2013 оны 08 сарын 01 өдөр

Дугаар 169

Улаанбаатар хот

Г Журам батлах тухай Г

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйл, Авто тээврийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.5.3-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. “Тээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэх ажил эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход баримтлах нөхцөл, шаардлагын тухай журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний загвар”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Тээврийн хэрэгслийн дугаарын тэмдгийн үйлдвэрлэл эрхлэх гэрээ”-ний загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Тушаал батлагдсантай холбогдуулан тээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэх ажил эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан гэрээг журмын шаардлагад нийцүүлэн шинэчилж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хяналт, бүртгэлийн газар /Б.Жаргал/-т даалгасугай.



А.ГАНСҮХ

Зам, тээврийн сайдын 2013 оны
8 дугаар сарын 1-ны өдрийн
169 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

**ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ДУГААР ҮЙЛДВЭРЛЭХ АЖИЛ ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХОД БАРИМТЛАХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫН
ТУХАЙ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Тээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэх ажил эрхлэх тусгай зөвшөөрлийг авто тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага (цаашид эрх бүхий байгууллага гэх) уг ажил, үйлчилгээний хэрэгцээг харгалзан олгоно.

Хоёр. Тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичиг

2.1. Тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгж, байгууллага дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.1.1. Тээврийн хэрэгслийн дугаарын тэмдэг үйлдвэрлэх санхүү, эдийн засгийн чадавхитай байх /татварын байгууллагад өргүй, тайлан баланс зөрчилгүй г.м. тодорхойлолт/;

2.1.2. Мэргэжлийн боловсон хүчинд тавигдах шаардлагыг хангасан байх /дугаарын үйлдвэрийн тоног төхөөрөмж дээр ажиллах чадвартай байх г.м./;

2.1.3. Холбогдох дүрэм, стандартын шаардлага хангасан, дугаарын үйлдвэрийн тоног төхөөрөмжид шаардагдах стандартаар тогтоосон талбай бүхий өөрийн буюу түрээсийн, үйлдвэрлэл үйлчилгээний ажлын байртай байх;

2.1.4. Ажлын байр нь галын болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг хангасан, ажиллагсдын эрүүл, аюулгүй ажиллах орчин нөхцлийг бүрдүүлсэн байх /үйлчлүүлэгчдийн хүлээлгийн танхим, ажилчдын амралтын болон ариун цэврийн өрөө, агааржуулалт г.м./;

2.1.5. “Тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг. Ерөнхий шаардлага” MNS4410:2002 улсын стандартын 4-т заасан дугаарын тэмдгийн хэлбэр, хэмжээ, тоо, үсэг хоорондын зайны хэмжээсүүдийг өөрчлөх боломжгүйгээр үйлдвэрлэх стандартын шаардлага хангасан тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, өндөр дараалтад тоног төхөөрөмжийн техникийн баримт бичиг, нийлүүлэх байгууллагатай хийсэн гэрээ;

2.1.6. Дугаарын бэлдэцийн ар талд байх тухайн үйлдвэрийн логоны загвар, тээврийн хэрэгслийн гэрчилгээн дээр тэмдэглэл хийх зориулалтын дардастай байх;

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ


ЭХ ХУВЬ

Санд, Ториин нарийн бичгийн дархан
сана дугаар тушаалт,

- 2.1.7. Тухайн ажил үйлчилгээний онцлог, зориулалтаас хамааран тээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэсэн мэдээллийг эрх бүхий байгууллагатай солилцох цахим сүлжээ нэвтрүүлэх техник, технологийн нөхцөлийг бурдүүлсэн байх.
- 2.2. Тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ аж ахуйн нэгж, байгууллага нь Авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр гаргана.
- 2.3. Тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгж, байгууллага хүсэлтийн хамт дор дурдсан баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:
- 2.3.1. “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”-ийн 11 дүгээр зүйлд заасан баримт бичиг;
- 2.3.2. Тусгай зөвшөөрөл олгоход тавигдах нөхцөл шаардлага /2.1/-ыг хангасан тухай танилцуулга, баримт бичиг.
- 2.4. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”-ийн 14.1.4-т заасны дагуу тухайн аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.
- 2.5. Тусгай зөвшөөрлийг үрэгдүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагад тусгай зөвшөөрөл нөхөн олгох тухай хүсэлт, тэмдэгтийн хураамж төлсөн баримтыг үндэслэн гэрчилгээг хүчинтэй хугацаагаар нь нөхөж олгоно.
- 2.6. Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан бол аж ахуйн нэгж, байгууллагад татгалзсан үндэслэлийг бичгээр хүргүүлнэ.

----- оОо -----





ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар ...

Зам. тээврийн сайдын 20... оны ... дугаар тушаалыг үндэслэн /хот,
аймаг/-ын /дүүрэг, сум/-д байрлах /оршин суух/..... тоот
улсын бүртгэлийн дугаартай, тоот регистрийн дугаартай
----- -д
/Аж ахуйн нэгж, байгууллагын нэр/

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ДУГААР ҮЙЛДВЭРЛЭХ АЖИЛ ЭРХЛЭХ

тусгай зөвшөөрлийг 20 ... оны ... дугаар сарын ... -ны өдрөөс жилийн
хугацаатай олгов.

САЙД



1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэр, байршил	Хаяг	Хаягын өөрчлөлт
/хот, аймаг//дүүрэг, сум/байршил/хот, аймаг//дүүрэг, сум/байршил


2. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАСАН ТЭМДЭГЛЭЛ

д/д	Тусгай зөвшөөрлийг сунгасан тухай тэмдэглэл	Сунгалт хийсэн	
		Тушаалын он, сар, өдөр	Гарын үсэг, тэмдэг

Энэхүү зөвшөөрөл нь гэрээний хамт хүчинтэй бөгөөд засвартай бол хүчингүй



Зам, тээврийн сайдын 2013 оны 07
дугаар сарын 01-ны өдрийн
169 дугаар тушаалын
гуравдугаар хавсралт



ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ДУГААРЫН ТЭМДГИЙН
ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭХ
ГЭРЭЭ

... оны ... дугаар
сарын ... -ны өдөр

№

Улаанбаатар
хот

1. Нийтлэг үндэслэл

1.1. Нэг талаас Зам, тээврийн яамыг төлөөлж Зам, тээврийн хяналт, бүртгэлийн газар, нөгөө талаас /аж ахуйн нэгж, байгууллагын нэр/ нар “Монгол Улсын Иргэний хууль” болон “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, “Авто тээврийн тухай хууль”-ийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь заалт, ... тоот тусгай зөвшөөрлийг үндэслэн тээврийн хэрэгслийн дугаарын тэмдэг үйлдвэрлэх ажил эрхлэх, түүнд хяналт тавих зорилгоор энэхүү гэрээг байгуулав.

1.2. Гэрээнд оролцогч талууд Монгол Улсад мөрдөгдөж буй холбогдох хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ биелүүлэн, хариуцлага хүлээнэ.

1.3. “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”-ийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтын дагуу тусгайлан заасан нутаг дэвсгэрт тээврийн хэрэгслийн дугаарын тэмдэг үйлдвэрлэх ажил эрхлэн гүйцэтгэнэ.

2. Зам, тээврийн яамны эрх, үүрэг

2.1. Зам, тээврийн сайдын 2013 оны ... дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Тээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэх ажил эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход баримтлах нөхцөл, шаардлагын тухай журам”, Стандартчилал, хэмжил зүйн үндэсний зөвлөлийн 2002 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 71 тоот тушаалаар батлагдсан “Тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг” MNS4410:2002 улсын стандартын шаардлагын биелэлтэд хяналт тавина.


2.2. Хууль, тогтоомж болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах эрхтэй.

2.3. /аж ахуйн нэгж, байгууллагын нэр/ нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллахад дэмжлэг үзүүлж ажиллах үүрэгтэй.

3. “...”-ийн эрх, үүрэг

/аж ахуйн нэгж, байгууллагын нэр/

3.1. Тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь мэргэжлийн байгууллагаар ажил үйлчилгээнийхээ чанар байдлыг үнэлүүлж, ажил үйлчилгээний



талаархи мэдээллийг нэгдсэн санд байршуулах, түүгээр дамжуулан сурталчуулах эрхтэй.

3.2. Зам, тээврийн сайдын 2013 оны ... дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Тээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэх ажил эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход баримтлах нөхцөл, шаардлагын тухай журам”, “Тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг” MNS4410:2002 улсын стандартын шаардлагыг чанд мөрдөж ажиллана.

3.3. Зам, тээврийн хяналт, бүртгэлийн газарт өөрийн үйлдвэрийн логоны болон тээврийн хэрэгслийн гэрчилгээн дээр тэмдэглэл хийх зориулалтын дардасны загварыг хүргүүлэх ба дугаарын тэмдгийг олгоходоо бэлдцийн ар тал, тээврийн хэрэгслийн гэрчилгээнд лого болон зориулалтын тэмдэглэгээг заавал хийнэ.

3.4. Дугаарын тэмдгийг захиалагчдад тээврийн хэрэгслийн гэрчилгээг үндэслэн үйлдвэрлэж өгнө.

3.5. Төв, орон нутгийн авто тээврийн бүртгэлийн албадад дугаарын тэмдгийг захиалгын дагуу үйлдвэрлэж нийлүүлнэ.

3.6. Үйлдвэрлэсэн дугаарын тэмдгийг автотээврийн хэрэгслийн зориулалт тус бүрээр төрөлжүүлж, мэдээллийг цахим бүртгэлд оруулж, мөн цаасан хэлбэрээр давхар хөтөлнө.

3.7. Хаяж үрэгдүүлсэн буюу хэрэглэгчийн хүсэлтийн дагуу дугаарыг шинэчлэн олгоходоо бүртгэлийн ахлах мэргэжилтний тодорхойлолтыг үндэслэнэ.

3.8. Үйлдвэрлэлийн сүүлийн үеийн дэвшилтэт шинэ технологийг нэвтрүүлж ажиллана.

3.9. Дугаарын тэмдгийн үнийг тогтвортой байлгах бодлого баримтлана.

3.10. Үйлдвэрийн үйл ажиллагааг хүндэтгэх шалтгаанаар түр буюу удаан хугацаагаар зогсоох тохиолдолд урьдчилан Зам, тээврийн хяналт, бүртгэлийн газарт бичгээр мэдэгдэнэ.

3.11. Дугаарыг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, хуурамчаар болон давхардуулж үйлдвэрлэхгүй байх.

3.12. Тээврийн хэрэгслийн дугаарыг үйлдвэрлэхдээ бэлдэц дээр нэр, хаяг, лого, утасны дугаар гэх мэт улсын стандартад нийцээгүй тэмдэглэгээг хэвлэхгүй байх.

4. Тээврийн хэрэгслийн дугаарын тэмдэг үйлдвэрлэх аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрийн байршил

4.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч -ийн тээврийн хэрэгслийн дугаарын тэмдэг үйлдвэрлэх үйлдвэрийн байршил / хот, аймаг/...../дүүрэг, сум/ хороо.....

4.2. Тээврийн хэрэгслийн дугаарын тэмдэг үйлдвэрлэх эрх авсан этгээд нь “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”-д зааснаас бусад тохиолдолд



бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах, шилжүүлэх, салбар, төлөөлөгчийн газар нээж ажиллуулахыг хориглоно.

5. Гэрээний хугацаа

5.1. Гэрээг ... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс ... оны ... дугаар сарын ...-ны өдрийг хүртэл нэг жилийн хугацаатайгаар байгуулав.

5.2. Талууд гэрээнд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулснаар хучин төгөлдөр болно.

6. Гэрээг дүгнэх

6.1. Гэрээний үүргийн биелэлтийг хагас, бүтэн жилээр Зам, тээврийн хяналт, бүртгэлийн газар дүгнэнэ.

6.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцалж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

7. Гэрээний бусад нөхцөл

7.1. Гэрээнд хоёр тал харилцан тохиролцож өөрчлөлт оруулна. Шаардлагатай тохиолдолд нэг талын санаачилгаар гэрээнд өөрчлөлт оруулах тухай санал тавьж болно. Гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний нэг хэсэг гэж үзнэ.

7.2. Энэхүү гэрээний 6.1-д заасны дагуу гэрээг жил бүр дүгнэсэн дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг сунгахыг шийдвэрлэнэ.

7.3. Талуудын хооронд маргаан гарвал хуульд заасан үндэслэл журмын дагуу шийдвэрлэнэ.

Гэрээ байгуулсан:

Зам, тээврийн яамны

-ИЙН

/аж ахуйн нэгж, байгууллагын нэр/

Зам, тээврийн хяналт,
бүртгэлийн газрын
дарга

захирал

Хаяг:

Хаяг:

